

ҮАГ

ҮАГ-ын 2015 оны аудитын төлөвлөгөөний дагуу хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан

**ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН 2014 ОН ХҮРТЭЛХ
ЗОРИЛТУУД БҮРЭН ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА**

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны
хөтөлбөрт тусгасан “Ажилтай орлоготой Монгол хүн”,
“Эрүүл чийрэг Монгол хүн” хөтөлбөрийн хэрэгжилт, үр
дүн

Тайлан бэлтгэсэн:

Гүйцэтгэлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор

М.Наранжаргал

Чиглэлийн албаны менежер:

Л.Эрдэнэчулуун

Ахлах аудитор:

С.Сэрчхорол

Р.Гончигцэрэн

Аудитор:

М.Доржмаа

Ж.Оюунтуяа

Шинжээч:

Г.Батсүх

Ш.Наранбаатар

УАГ-ын гүйцэтгэлийн болон аймаг, нийслэлийн аудитын газрын аудитор, шинжээчид оролцов.

2015 оны 6 дугаар сар

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 262451, 261675, 261805 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

Уг тайланг УАГ-ын Веб сайт-аас үзнэ үү. www.audit.mn

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Засгийн газрын IV байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-46
Монгол Улс

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт..... 2

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл 3

Аудитын хураангуй 5

Бүлэг 1. Ажилтай, орлоготой монгол хүн хөтөлбөрийн хэрэгжилт

- Хөтөлбөрийн хүрээнд 163 зорилт, 586 дэд арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна 6
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 29.1 их наяд төгрөгийн эх үүсвэр төлөвлөсөн байна 7
- “Ажилтай орлоготой монгол хүн хөтөлбөр”-ийн зорилтууд бүрэн хангагдаагүй байна 8
- Нийт төсөвлөсөн эх үүсвэрийн 9.7 хувь, 2012-2014 онд хэрэгжүүлэх арга хэмжээ 27.2 хувиар санхүүжигдсэн байна 11

Бүлэг 2. Эрүүл чийрэг монгол хүн хөтөлбөрийн хэрэгжилт

- Хөтөлбөрийн хүрээнд 22 зорилт, 49 дэд арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна 13
- “Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийн зорилт бүрэн хангагдаагүй байна 13
- Салбарын зорилт, арга хэмжээний болон үндсэн үзүүлэлт хүрэх түвшинд хүрч хангагдаагүй байна 14

Бүлэг 3. Хөтөлбөрийн өнөөгийн үр дүнг харгалзан зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна

- Хөтөлбөрийн хэрэгжилтийн төлөв байдалд үнэлэлт өгч, цаашид хэрэгжүүлэх гол асуудлыг тодорхойлох шаардлагатай байна 17
- Нийгэм, эдийн засгийн байдлын зарим үзүүлэлтийн түүвэр судалгааны дүн 20

Дүгнэлт 22

Холбогдох байгууллагын санал:

ЗГХЭГ-аас ирүүлсэн санал 23

Саналд өгсөн тайлбар: 25

Зөвлөмж: 26

ХАВСРАЛТУУД:

Хавсралт А. “Ажилтай орлоготой монгол хүн” хөтөлбөрийн бүрэн хангагдаагүй зорилт, арга хэмжээний жагсаалт..... 27

Хавсралт Б. “Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийн бүрэн хангагдаагүй зорилт, арга хэмжээний жагсаалт..... 41

Хавсралт В. Зарим салбар хариуцсан яамдын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт 42

Хавсралт Г. Хөдөлмөр эрхлэлт, ЭМ-ийн зарим үзүүлэлтийн түүвэр судалгаа..... 43

Хавсралт Д. Нийгэм, эдийн засгийн байдлын зарим үзүүлэлтийн түүвэр судалгаа..... 44

Товчилсон үгийн тайлбар

АНАГ	Аймаг, нийслэлийн аудитын газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗТЯ	Зам, тээврийн яам
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГҮАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗГҮАХХАХТ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
МТШХХГ	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа, холбооны газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал
УУЯ	Уул уурхайн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
ХЗЯ	Хууль зүйн яам
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
ХХИ	Хүний хөгжлийн индекс
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам (хуучнаар)
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМСЯ	Эрүүл мэнд, спортын яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 20 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт 2015 онд нийлүүлэх аудитын төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Ажилтай, орлоготой монгол хүн”, “Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулж үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд доорх чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- *Төрийн захиргааны байгууллагууд хөтөлбөрийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан эсэх;*
- *Хөтөлбөрийн гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнах, үр дүнг бодитой үнэлсэн эсэх.*

Хамарсан хүрээ

Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Ажилтай, орлоготой монгол хүн”, “Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийн гол зорилтын дагуу арга хэмжээний үндсэн болон хамтран хэрэгжүүлэгч, мөн бусад оролцогч, аймаг нийслэлийн зарим төрийн байгууллага, хөтөлбөр хэрэгжүүлэгч, мэдээлэл боловсруулагч зэрэг нийт 30 гаруй байгууллагууд дээр ажиллав.

Арга зүй стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглав. Үүнд:

- *Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Ажилтай, орлоготой монгол хүн”, “Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийг үндсэн хэрэгжүүлэгч байгууллагуудын болон ЗГХЭГ-ын гаргасан тайлан, мэдээ, биелэлтийг үнэлэх;*
- *Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгийн үндэслэл тооцоолол, зарцуулалтыг хянан үзэх;*
- *Хамрах хүрээний байгууллагуудын холбогдох албан тушаалтнаас ярилцлага, асуулга, тодруулга, лавлагаа авах, тоон мэдээлэл, судалгаа гаргуулан дүн шинжилгээ хийх;*
- *Яамдын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газруудын хөтөлбөрийн хэрэгжилт, гүйцэтгэлийг үнэлсэн үнэлгээний тайланг судлах;*
- *ТЕЗ тус бүрээр аудитын дэд тайланг бэлтгэж, хэрэгжилтийн байдлыг танилцуулах;*
- *Аудитын хөтөлбөр, арга зүй, горимын дагуу цуглуулсан баримт материалд дүн шинжилгээ хийх, зарим арга хэмжээг түүвэрчлэн нотлох зүйлстэй тулган баталгаажуулах;*
- *Салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагуудын бүс орон нутагт хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн байдалд ҮАГ-ын харьяа аймаг, нийслэл дэх аудитын газруудаас ирүүлсэн судалгаа, тодруулгад үндэслэн тайланд тусгах.*

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээний бүс орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа талаар АНАГ-уудаас тодруулга авч аудитын дүнд нэгтгэв.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын хураангуй

Улсын Их Хурлын 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоолоор Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг, Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 120 дугаар тогтоолоор үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус баталжээ.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Ажилтай, орлоготой” /1/, “Эрүүл чийрэг” /2/, “Эрдэм боловсролтой” /3/, “Аюулгүй орчинтой” /4/, “Эрх чөлөөтэй” /5/ монгол хүн гэсэн 5 бүлэг бодлогын зорилтыг дэвшүүлсэн байна.

Засгийн газрын “Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд 5 бүлэг 319 үндсэн зорилтын хүрээний 1104 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас “Ажилтай, орлоготой монгол хүн” бүлэгт 163 зорилт, 586 арга хэмжээ, “Эрүүл чийрэг монгол хүн” бүлэгт 22 зорилт, 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Хөтөлбөрийн биелэлтийн байдлыг авч үзэхэд:

- “Ажилтай, орлоготой монгол хүн” хөтөлбөр 2014 оны байдлаар 46.8 хувийн биелэлттэй буюу нийт 586 арга хэмжээнээс хангалтгүй хэрэгжилттэй 191 арга хэмжээ байна. (Хавсралт А)
- “Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийн “54.3” хувийн биелэлттэй буюу нийт 49 арга хэмжээнээс хангалтгүй хэрэгжилттэй 11 арга хэмжээ байна. (Хавсралт Б)

Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зарим зорилт, арга хэмжээний биелэлт хангалтгүй байгаагийн гол шалтгааныг эдийн засгийн өсөлт саарсан, орлого, хөрөнгө санхүүгийн эх үүсвэр дутагдалтай холбон тайлбарлаж байгаа ч шийдвэрлэвэл зохих асуудлууд хугацааны хувьд ихээхэн алдагдалтай байх, төлөвлөлт судалгааны ажил хангалтгүйгээс хэрэгжих суурь нөхцөл бүрдээгүй зорилт, арга хэмжээг төлөвлөсөн, хэрэгжилтийн явцыг үр дүнд чиглүүлэн хянан удирдаагүйтэй холбоотой байна.

Мөн зорилт, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийн тооцоолол, улсын төсөв болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн бодит гүйцэтгэл, үр ашигт байдлын талаар тайлагнаагүй, энэ талаархи мэдээ, тайлан, тооцоо судалгаа хийгдээгүй байна.

Сайжруулах асуудал

Мөрийн хөтөлбөрт тусгагдсан томоохон зорилт, арга хэмжээг хэрэгжих хугацаа, хөрөнгө санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан төлөвлөөгүй, хөтөлбөрийг хэрэгжүүлэх шуурхай удирдлага, зохион байгуулалтын ажил дутмаг, эрх зүйн орчныг бий болгох шинэчлэлийн хүрээний арга хэмжээний хэрэгжилт хугацаа алдаж байгаа нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарч буй гол эрсдэл болж байна.

ЗГХЭГ болон асуудал хариуцсан төрийн байгууллагуудаас хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гарч буй зардлын үр ашиг, үр дүнг тооцох арга зүйг боловсруулан ашиглах, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, чадавхийг сайжруулах талаарх ажлын үр дүн хангалтгүй байна.

Бүлэг 1. “Ажилтай, орлоготой монгол хүн” хөтөлбөрийн хэрэгжилт

Хөтөлбөрийн хүрээнд 163 зорилт, 586 дэд арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна

1.1 Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны “Ажилтай орлоготой монгол хүн хөтөлбөр”-ийн хүрээнд үндсэн 163 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.2 Засгийн газраас үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртөө тусгагдсан “Ажилтай, орлоготой монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 2013 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 154 дүгээр тогтоолоор “Үндэсний хөтөлбөр”-ийг 2013-2016 онд хэрэгжүүлэхээр баталсан байна.

1.3 Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Ажилтай, орлоготой монгол хүн” хөтөлбөрийг бодит үр дүнд хүргэхийн тулд бодлогын хүрээнд дараах асуудлуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

Хамаарал	Үндсэн зорилт, арга хэмжээ
▪ Макро эдийн засгийн хүрээний гол зорилт нь:	Хүн амын үндсэн хэрэгцээг тогтвортой хангахуйц, өөрийгөө тэтгэх, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай эдийн засгийг бүрдүүлэхэд чиглэгдсэн төсөв, санхүү, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд орших;
▪ Бодлогын дэмжлэг, үйл ажиллагааны гол чиглэл нь:	Хөдөлмөрийн насны иргэдийг ажлын байраар хангах, тэдний цалин хөлс нь амьдрал ахуйд нь хүрэлцдэг болгох, хавтгайрсан нийгмийн халамжийн бодлогоос татгалзаж, халамж шаардагдах хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжихэд;
▪ Тэргүүлэх зорилт нь:	Төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргаж, бизнест ээлтэй орчныг бүрдүүлэхэд;
▪ Анхаарлын төвд байлгах арга:	Жендерийн зохистой харьцаа алдагдсан салбарыг онцгой анхаарч ажиллана гэж тус тус томъёолжээ.

1.4 Мөрийн хөтөлбөрийн зорилтыг хангахын тулд дээрх бодлогын чиглэл, үйл ажиллагааны дэмжлэг болон хийгдэх шинэчлэлийг эдийн засаг, нийгмийн зохих салбаруудаар дамжуулан хэрэгжүүлэхээр төлөвлөхдөө:



- I. Бодлогын зорилтуудыг дэмжсэн шинэчлэлийн хүрээний 10;
- II. Зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мөрдлөг болгох зарчмын 8;
- III. Эдийн засгийн бодит салбаруудаар дамжуулан баримтлах зарчим, үйл ажиллагааны 18;
- IV. Уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр бодлогын 19;
- V. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын 5;
- VI. Нийгмийн хамгааллын бодлогын хүрээний 15;
- VII. Эдийн засгийг солонгоруулах 7 бодлогын хүрээний 88, нийт 163 дэд бүлэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

1.5 Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үндсэн 163 зорилтыг хэрэгжүүлэхдээ түүнийг дэмжсэн нийт 586 дэд арга хэмжээг баталсан байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 29.1 их наяд төгрөгийн эх үүсвэр төсөвлөсөн байна

1.6 ЗГҮАХХАХТ-нд “Ажилтай, орлоготой монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 29.1 их наяд төгрөг, мөн гадаад эх үүсвэрээс 10.7 тэрбум ам.доллар, 29.9 тэрбум иентэй тэнцэхүйц хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэрийг баталсан байна. (Хүснэгт 1)

1.7 Нийт хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийн /төгрөгийн/ 45.5 хувь буюу 13.3 их наяд төгрөг улсын төсвөөс, 15.1 хувь буюу 4.4 их наяд төгрөг гадаадын зээл тусламжаар, 23.3 хувь буюу 6.7 их наяд төгрөг хувийн хэвшлээс, 10.2 хувь буюу 2.9 их наяд төгрөг Хөгжлийн банкнаас, 5.9 хувь буюу 1.7 их наяд төгрөгийг тусгай сан болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ гэж тооцсон байна.

Хүснэгт 1: Санхүүжилтийн эх үүсвэр (холбогдох валютаар)

№	Ангилал	тбм.төг	тбм ам/дол	тбм.иен
1	Улсын төсөв	13 251.4	-	-
2	Гадаад зээл, тусламж	4 382.1	10.7	29.9
3	Тусгай сан, бусад	1 700.1	-	-
4	Хувийн хэвшил	6 782.7	-	-
5	Хөгжлийн банк	2 977.6	-	-
	Дүн	29 093.9	10.7	29.9

1.8 Харин хөтөлбөрийн хүрээнд 2012-2014 онд хэрэгжүүлж дуусгах зорилт, арга хэмжээнд төлөвлөсөн хөрөнгийн эх үүсвэрийг авч үзвэл улсын төсвөөс 5.3 их наяд төгрөг, гадаадын зээл, тусламжаар 1.4 тэрбум ам.долларын эх үүсвэр ашиглана гэж тооцсон байна.

1.9 Төлөвлөсөн 163 зорилт, 586 арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаагаар төлөвлөсөн байдлыг авч үзвэл:

Хүснэгт 2: Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжих хугацаа (он)

Хугацаа																	
Он	2012	2013	2014	2012 2013	2012 2014	2013 2014	2012 2015	2012 2016	2013 2015	2014 2015	2015 2016	2016 2017	2017 2018	2018 2019	2019 2020	2020 2021	2021 2022
Арга хэмжээ	11	43	6	41	45	65	22	147	43	8	127	28	4	1	1	1	1

1.10 Судалгаанаас харахад хөтөлбөр хэрэгжих нийт хугацааны эхний хагаст буюу 2012-2014 онд биелэлтийг хангасан байх 211 арга хэмжээ /36%/, нийт хугацаанд буюу 2012-2016 онд хэрэгжих 373 арга хэмжээ /63.6%/, 2011 оноос хэрэгжиж байгаа 2 арга хэмжээг үргэлжлүүлэх, 2017 онд хэрэгжүүлж дуусгах 1 арга хэмжээг тус тус баталсан байна.

1.11 “Ажилтай, орлоготой монгол хүн” хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг үндсэн хэрэгжүүлэгч байгууллага болон хэрэгжих хугацаагаар авч үзвэл;

Хүснэгт 3: Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ (төсвийн ерөнхийлөн захирагчдаар, тоо)

№	ТЕЗ	Арга хэмжээ /тоо/	2011-2017 он					2012-2014 он					2013 - 2014
			2012- 2014	2012- 2016	2011- 2015	2011- 2016	2014- 2017	2012	2013	2014	2012 - 2013	2012- 2014	
1	ГХЯ	1		1									
2	БШУЯ	2		2									
3	ЭМЯ	2		2									
4	СЗХ	2	1	1									1
5	ЦЕГ	4		4									

6	НЗДТГ	5		5									
7	МБ	6	2	4							1	1	
8	ЗГХЭГ	6	5	1				1	3				1
9	ШС	10	4	6						1	2	1	
10	БОНХЯ	13	2	11					1				1
11	МТШХХГ	19	1	17		1			1				
12	ССАЖЯ	25	7	18							1	6	
13	СЯ	28	7	21					1	1	2	3	
14	ХАХНХЯ	29	14	15			2	2	2		1	7	
15	ХЯ	33	8	25			2	4		2			
16	ЭХЯ	34	10	24				2		1	5	2	
17	УУЯ	43	10	33				2	1	3	1	3	
18	ЗТЯ	66	36	29	1		2	5		14	10	5	
19	ЭЗХЯ	75	37	38			4	9	2	8	6	9	
20	БХБЯ	80	32	48				5	1	7	7	11	
21	ҮХААЯ	103	36	67		1		8		4	9	14	
Дүн		586	211	372	1	1	1	11	43	6	41	45	65

1.12 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан нийт зорилт, арга хэмжээний 55.6 хувийг ҮХААЯ(хуучнаар), БХБЯ, ЭЗХЯ(хуучнаар), ЗТЯ үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар, 44.4 хувийг бусад яам, газрууд хамтран гүйцэтгэхээр үүрэг хүлээсэн байна.

1.13 Судалгаанаас харахад 2012-2014 онд хэрэгжиж дууссан байвал зохих арга хэмжээний 28.1 хувь 2012, 2013, 2014 онд, үлдсэн 71.9 хувь 2012-2013 он дамжин хэрэгжихээр батлагдсан байна.

“Ажилтай, орлоготой монгол хүн” хөтөлбөрийн зорилтууд бүрэн хангагдаагүй байна

1.14 Хөтөлбөрийн хэрэгжилтийг 2014 оны байдлаар авч үзэхэд үндсэн хариуцагч байгууллагуудын гаргасан биелэлтийн дундаж 61.7 хувь, харин ЗГХЭГ-ын тайлагнаснаар 53.9 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна. Үүнд:

Хүснэгт 4: ЗГХЭГ-аас хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэсэн байдал (тоо, хувь)

Он	Зорилтын тоо	Биелэлтийн түвшин									
		“0”	“10”	“30”	“40”	“50”	“60”	“70”	“80”	“90”	“100”
2013	163	2	22	57	-	37	-	32	-	3	10
2014	163	1	5	29	20	38	17	32	3	13	5

1.15 Хүснэгтээс үзэхэд 2014 оны байдлаар нийт дэвшүүлсэн зорилтын 57.1 хувь нь 0-50.0 хувийн биелэлттэй бөгөөд зарим зорилтын хэрэгжилт өмнөх оныхоос буурч үнэлэгдсэн нь хэрэгжүүлэгч байгууллагуудаас хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж, дүгнэхдээ бодитой бус хандсаны нэг илрэл юм. Тухайлбал,

ЗГҮАХХАХТ-ний:

- 129-ийн “Аймгийн төвд төрөөс иргэдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын орчныг утасгүй интернетийн бүсэд хамруулах”,
- 32-ын “Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг дэмжиж иргэд, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах”,
- 28-ын “Гадаадын төрийн өмчит компаниудын хөрөнгө оруулалтыг хянан зохицуулсан бодлого хэрэгжүүлэх”,
- 25-ын “Бусад улстай хийсэн давхар татварын гэрээг Монгол Улсын эрх ашигт нийцүүлэн шинэчлэх, эсхүл хүчингүй болгох”,
- 100-ын Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг бий болгох”

зорилт өмнөх онд **бүрэн хэрэгжсэн** гэж үнэлэгдсэн бол 2014 оны тайлагналаар буурч үнэлэгджээ.

1.16 ЗГҮАХХАХТ-нд тусгагдсан “Ажилтай орлоготой монгол хүн” хөтөлбөрийн хүрээний нийт 586 арга хэмжээний хэрэгжилт дунджаар “46.8” хувийн биелэлттэй ба дараах байдлаар үнэлэгдэж байна. Үүнд:

Хүснэгт 5: Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлсэн байдал (тоо, хувь)

Үзүүлэлт		Үнэлгээний түвшин					
Биелэлт	Хувиар	“0-10”	“11-30”	“31-50”	“51-70”	“71-90”	“91-100”
Арга хэмжээ /586/	Тоо	75	121	123	90	81	96

1.17 ЗГҮАХ-т тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийн байдлаас үзэхэд 54.4 хувь “0-50”, 29.2 хувь “51-90”, 16.4 хувь “91-100” хувийн хэрэгжилттэй байна.

1.18 Зарим ТЕЗ-дын хариуцсан арга хэмжээний биелэлтийг авч үзвэл:

- ЭЗХЯ (хуучнаар)-ны хариуцсан 75 арга хэмжээнээс “0-50.0” хувийн биелэлттэй 48,
- БХБЯ-ны хариуцсан 80 арга хэмжээнээс “0-50.0” хувийн биелэлттэй 50,
- МТШХХГ-ын хариуцсан 19 арга хэмжээнээс “0-30.0” хувийн биелэлттэй 13,
- ҮХААЯ-ны хариуцсан 103 арга хэмжээнээс “0-50.0” хувийн биелэлттэй 88,
- ССАЖЯ (хуучнаар)-ны хариуцсан 25 арга хэмжээнээс “0-50.0” хувийн биелэлттэй 21,
- ЗТЯ-ны хариуцсан 66 арга хэмжээнээс “0-50.0” хувийн хэрэгжилттэй 30 буюу дийлэнх арга хэмжээний биелэлт хангалтгүй түвшинд байна.

1.19 “Ажилтай, орлоготой монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд 2012-2014 онд хэрэгжиж дууссан байхаар батлагдсан 90 зорилтын хүрээний 211 арга хэмжээнээс “91-100” хувийн биелэлттэй 44 байгаа бол “51-90” хувийн гүйцэтгэлтэй 68, “0-50” хувийн гүйцэтгэлтэй 99 арга хэмжээ байна.

Дүрслэл 1: Зорилт, арга хэмжээний биелэлт (тоо, хувь)



1.20 Мөн 2012-2014 оны байдлаар “0-30” хувийн биелэлттэй арга хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч үзвэл ЭЗХЯ (хуучнаар) 17, БХБЯ 13, ҮХААЯ 13, ХАХНХЯ 6, ЗТЯ 6, УУЯ 3, ССАЖЯ (хуучнаар) 2 зорилтын хүрээний арга хэмжээ хөтөлбөр хэрэгжих хугацааны тэн хагаст тодорхой суурь тавигдаагүй, хэрэгжилт удаашралтай байгаа бөгөөд зарим зорилтыг дурдвал:

- Хөрөнгө оруулалтыг тав хүртэл жилээр төлөвлөх зарчимд шилжих /15/,
- Хөдөлмөрийн багтаамж ихтэй салбаруудыг бодлогоор дэмжиж ажлын байр нэмэгдүүлэх /30/,
- Санхүүгийн секторын шинэтгэлийг бодит сектор, тухайлбал, уул уурхайн бус эдийн засгийн бусад салбар, жижиг, дунд бизнесийн өсөлтийг дэмжих, хувийн даатгалын ба хөрөнгө оруулалтын сангууд, хувийн тэтгэврийн сангийн болон зээлийн батлан даалтын тогтолцоог хэрэгжүүлэх чиглэлээр орчин үеийн санхүүгийн зах зээлийн өрсөлдөөнт орчныг бий болгоход чиглүүлэх /35/,
- Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох /40/,
- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын жагсаалтыг шинэчлэн томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулахыг эрчимжүүлэх, Стратегийн ач холбогдол бүхий ордын төрийн эзэмшлийг нэгтгэн, корпорацийн

зохион байгуулалтад оруулж, Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу иргэдэд давуу эрхийн хувьцаа олгох /43/

- Аймаг, бүс нутгийн онцлогт тулгуурласан аялал жуулчлалын хөтөлбөр хөгжүүлэх /86/,
- Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарыг бие даасан, цөөн орноос хамааралтай байдлыг арилгахад анхаарч өрсөлдөх чадварыг бэхжүүлэх /31/,
- Олон улсын жишигт нийцсэн орчин үеийн терминал төвийг Замын–Үүд, Алтанбулаг, Улаанбаатар хотод байгуулах /119/,
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлогыг нийгэм, эдийн засаг, байгаль орчин зэрэг хөгжлийн бүх үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх /163/.

1.21 Аймгийн аудитын тайлангаас үзэхэд орон нутаг, бүсийн хэмжээнд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн зарим зорилт, арга хэмжээ хангалтгүй байна. Тухайлбал,

ЗГҮАХХАХТ-ний:

- 76.1, 76.2-т тусгагдсан зорилтын хүрээнд Увс аймагт 2012-2013 онд Швейцарийн хөгжлийн агентлагийн “Баруун бүсийн мэргэжлийн боловсрол, сургалт төсөл”-ийн хөрөнгө оруулалтаар сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулсан боловч өнөөг хүртэл үйл ажиллагаа явагдаагүй;
- 112 дугаар зорилтын дагуу хэд хэдэн чиглэлээр арга хэмжээг төлөвлөж “Ховд-Улаангом” чиглэлийн 190 км авто замыг 2013-2015 онд барьж ашиглалтад оруулна гэсэн ч дэд арга хэмжээнд батлагдаагүй, хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй;
- 34.18-д шинээр баригдах төмөр замын дагуу GPS сүлжээ байгуулах 1:25000 масштабтай байр зүйн зураглалыг 2012-2013 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч хэрэгжээгүй;
- 77 дугаар зорилтын хүрээнд Сэлэнгэ аймагт 2013-2014 бүрэн хэрэгжсэн байх мал нядалгааны цехэд мал нийлүүлсэн малчдад урамшуулал олгогдоогүй;
- Баянхонгор аймагт хөтөлбөр хэрэгжсэний үр дүнд нэмэгдсэн байнгын болон түр ажлын байрны мэдээллээр ажилгүйдлийн тоо буурч байгаа хэдий ч жил бүр бүртгэгдэж буй ажилгүй иргэдийн тоо буураагүй байгаа нь хэрэгжилтийн үнэлгээ бодит байдлаас зөрүүтэй;
- Дархан-Уул аймгийн хэмжээнд хөтөлбөрийг 2013 онд 57.4 хувийн биелэлттэй гэж байсан боловч 2014 онд хэрэгжүүлэгч байгууллагууд ажлыг эрчимжүүлэх, хяналт тавьж ажиллах, хүрэх түвшин, үр дүнд анхаарч ажиллаагүй;
- Хэнтий аймгийн ЗДТГ-аас хэрэгжүүлэх зорилтыг төлөвлөгөөнд тодорхой заагаагүй гэснээр 11 арга хэмжээний биелэлтийг тайлагнаагүй зэрэг бодит байдлыг дурдаж болохоор байна.

1.22 Хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн бодлогын зорилтуудыг дэмжсэн нийт арга хэмжээний хэрэгжилтийг хамрах хүрээгээр авч үзвэл,

Хүснэгт 6: Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний биелэлт, (тоо, хувь)

Д.д	Дэвшүүлсэн бодлого, зорилтын хамрах хүрээ	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилт	
				“0-30%”	“31-100%”
1	Шинэчлэлийн хүрээ	10	52	14	38
2	Зарчмын мөрдлөг	8	22	4	18
3	Үйл ажиллагааны хүрээ	18	64	14	50
4	Уул уурхайн салбарыг хөгжүүлэх	19	64	14	50
Эдийн засгаа солонгоруулах бодлого					
1	Үйлдвэржүүлэх чиглэл	12	57	23	34
2	Ноос, ноолуур, арьс ширний чиглэл	3	9	3	6
3	Уламжлалт мал аж ахуй, мах, сүүний чиглэл	8	33	12	21
4	Аялал, жуулчлалыг хөгжүүлэх чиглэл	10	33	17	16
5	Өндөр технологи, био, нано, мэдээллийн технологийн чиглэл	4	14	4	10

6	Импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих чиглэл	12	45	29	16
7	Үйлчилгээний бизнесийг дэмжих чиглэл	39	143	53	90
8	Хөдөлмөр эрхлэлтийн бодлого	5	18	1	17
9	Нийгмийн хамгааллын бодлого	15	32	7	25
Нийт		163	586	195	391

1.23 Эдийн засгаа солонгоруулах 7 бодлогын хүрээний “Үйлдвэржүүлэх, аялал, жуулчлал хөгжүүлэх, импортыг орлосон экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, үйлчилгээний бизнесийг дэмжих” чиглэлээр дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт хангалтгүй, удаашралтай байна. Тухайлбал:

ЗГҮАХХАХТ-ний:

- Уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулах зорилгоор аж үйлдвэрийн анхны паркийг Дорноговь аймгийн Сайншанд хотод байгуулах /56/,
- Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүс, Алтанбулаг болон Цагааннуурын чөлөөт бүсийн дэд бүтцийг цогцоор нь барьж дуусгах /58/,
- Уул уурхайн бус экспортыг дэмжих, хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хувийн хэвшлийн оролцоо, манлайлалтай боловсруулан хэрэгжүүлэх. Уул уурхайн салбарын экспортын орлогын тодорхой хэсгээс уул уурхайн бус экспортын хөгжлийн сан байгуулах /60/,
- Мах, махан бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах зорилгоор махны нийлүүлэлтийн шинэ тогтолцоог бүрдүүлэх /77/,
- УИХ-аас баталсан “Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот” хөтөлбөр, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д тусгагдсан төмөр замыг барьж байгуулах /107/.

1.24 УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоолын 2.2-т “Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж байхаар баталсан.

1.25 Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Ажилтай, орлоготой монгол хүн” хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээнээс үндсэндээ тусгагдаагүй бөгөөд харин 2014 оны үндсэн чиглэлд зорилт, бодлогын хүрээний 40 гаруй арга хэмжээ тусгагдсан байна.

1.26 Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2014 оны үндсэн чиглэлд тусгагдсан хэрэгжих хугацаа дууссан 9 арга хэмжээнээс 90-100 хувийн биелэлттэй 6, 70 хувийн биелэлттэй 1, 30 хувийн биелэлттэй 2 арга хэмжээ байна. Үүнд:

- Үндсэн чиглэлийн бодит салбарын хөгжлийн бодлогын 5.8-д тусгагдсан “Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор улсын шатахууны нөөц хадгалах агуулах барьж байгуулах;
- Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээний 15.1-ийн “Төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлого, хууль эрх зүйн орчныг шинэчлэх”.

Нийт төсөвлөсөн эх үүсвэрийн 9.7 хувь, 2012-2014 онд хэрэгжүүлэх арга хэмжээ 27.2 хувиар санхүүжигдсэн байна

1.27 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрт 2012-2014 онд улсын төсвөөс 565.4 тэрбум төгрөг, гадаадын зээл, тусламжаар 167.9 сая ам.доллар, 165.7 тэрбум төгрөг, 8.29 сая евро, хөгжлийн

банкнаас 161.8 сая ам.доллар, 626.3 тэрбум төгрөг, тусгай сангаас 520.6 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан нь нийт төсөвлөсөн хөрөнгийн 9.7 хувь болж байна.

1.28 Харин 2012-2014 онд хэрэгжүүлэх арга хэмжээнд төсөвлөсөн хөрөнгийн 27.2 хувь, гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн 18.2 хувь зарцуулагдсан байна. Үүнд:

- Улсын төсвөөс 748.2 тэрбум төгрөг;
- Бондын хөрөнгө 574.4 тэрбум төгрөг;
- Зээлийн эх үүсвэрээр 123.3 тэрбум буюу нийт 1,445.9 тэрбум төгрөг;
- Гадаад эх үүсвэрээс 254.7 сая ам.доллар тус тус зарцуулагджээ.

1.29 Засгийн газраас 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор баталсан¹ “Үндэсний хөтөлбөр” нь төр-хувийн хэвшлийн түншлэл, өөртөө ажлын байр бий болгох иргэдийн санаачлагад тулгуурласан хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг бусад салбарын бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх замаар 150.0 мянгаас доошгүй байнгын шинэ ажлын байр бий болгож, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна.

1.30 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтэд нийцүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үйлчилгээ, арга хэмжээг төсөл, хөтөлбөрүүдийн хэлбэрээр хэрэгжүүлсний үр дүнд 2013 онд 59.8 мянга, 2014 онд 55.9 мянган хүн тус тус ажлын шинэ байраар хангагджээ.

1.31 2014 онд хангагдсан ажлын шинэ байрны 91.5 хувь буюу хувийн болон хувь хүн иргэний өмчийн хэлбэр давамгайлж байна. Гэвч статистик мэдээллээс үзэхэд хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтийн түвшин хангалтгүй, мөн “Үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд үнэлгээ хийгдээгүй байна.

1.32 Эдийн засгийн өсөлт саарах болон бусад хүчин зүйлийн үед ажлын байрыг хадгалж үлдэх, цаашид шинээр болон тогтвортой ажлын байр нэмэгдүүлэхэд хөдөлмөр эрхлэлттэй холбогдох хууль эрх зүйн шинэчлэлийг төлөвлөсөн хугацаандаа боловсруулан батлуулах, цалин хөлсний бодлогыг боловсронгуй болгох асуудлууд хугацаа алдаж байна.

¹ Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн “Ажилтай орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөр батлах тухай 154 дүгээр тогтоол

Бүлэг 2. “Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийн хэрэгжилт

Хөтөлбөрийн хүрээнд 22 зорилт, 49 дэд арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна

2.1. Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд 5 бодлогын зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- I. Иргэний эрүүл мэндийн даатгалын шинэчлэлийг хийх;
- II. Эх орондоо чанартай оношилгоо, эмчилгээ хийлгэх боломжийг бүрдүүлэх;
- III. Орлого багатай иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулахад дэмжлэг үзүүлэх;
- IV. Импортын эмийн болон хүнсний аюулгүй байдлыг хангах шинэчлэлийг хийх;
- V. Монгол хүний эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах.

2.2. Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд 2012-2016 онд хэрэгжүүлэх 22 дэд зорилт, түүнийг дэмжсэн 49 арга хэмжээг ЗГҮАХХАХТ-нд тусгасан бөгөөд нийт 532.1 тэрбум төгрөгийн зардал, санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай гэж тооцжээ.

Хүснэгт 7: Санхүүжилтийн эх үүсвэр (тбм.төг)

№	Ангилал	Хөрөнгийн хэмжээ
1	Улсын төсөв	138.7
2	Инновацийн сан, ХБ	40.0
3	ЭМДС	153.4
4	Бусад	200.0
Дүн		532.1

2.3. “Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2012-2014 онд 36.4 хувь буюу 18, 2012-2016 онд 55.5 хувь буюу 27, 2014-2016 онд 8.1 хувь буюу 4 арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр баталсан байна.

“Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийн зорилт бүрэн хангагдаагүй байна

2.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг 2014 оны байдлаар авч үзэхэд үндсэн хариуцагч байгууллагуудын гаргасан биелэлтийн дундаж 67.7 хувь, харин ЗГХЭГ-ын тайлагнаснаар 49 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

2.5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төсөвлөсөн санхүү, хөрөнгийн эх үүсвэрийн ашиглалт, зарцуулалтын талаарх 2013 оны мэдээллийг үндсэн хариуцагч байгууллага гаргаагүй бөгөөд 2014 онд нийт 66.2 тэрбум төгрөгийн эх үүсвэр буюу нийт хөрөнгийн 12.4 хувь зарцуулагдсан байна.

2.7 Хөтөлбөрийг үндсэн хариуцагч байгууллагууд дараах байдлаар үнэлсэн байна. Үүнд:

- ХАХНХЯ-ны хариуцсан 6 арга хэмжээний биелэлт 45.0 хувь;
- ЭМСЯ-ны 35 арга хэмжээний биелэлт 63.3 хувь;
- Шадар сайдын 3 хариуцсан арга хэмжээний биелэлтийг тооцоогүй;
- Ерөнхий сайдын хариуцсан 1 арга хэмжээний биелэлт 50.0 хувь;
- ҮХААЯ-ны (хуучин нэрээр) хариуцсан 4 арга хэмжээний биелэлт 50.0 хувьтай хэрэгжсэн гэж тайлагнажээ.

2.8 ЗГҮАХХАХТ-нд тусгагдсан “Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийн хүрээний нийт 49 дэд арга хэмжээний хэрэгжилт дунджаар “45.3” хувийн биелэлттэй, үүнээс бүрэн хэрэгжсэн 5, хэрэгжилт дутуу 41, хэрэгжээгүй 3 байна. Үүнд:

- “0-10” хувийн хэрэгжилттэй 3;
- “30-50” хувийн хэрэгжилттэй 25;
- “70-80” хувийн хэрэгжилттэй 16;
- “90-100” хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээ байна.

2.9 “Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд 2012-2014 онд хэрэгжиж дууссан байхаар батлагдсан 18 арга хэмжээний хэрэгжилт 55.5, 2012-2016 онд буюу нийт хугацаанд хэрэгжих 27 арга хэмжээний хэрэгжилт 54.0, 2014 оноос эхлүүлсэн 4 арга хэмжээний хэрэгжилт 27.5 хувийн биелэлттэй байна.

2.10 2012-2014 онд хэрэгжих арга хэмжээний хэрэгжилтийг хянан үзэхэд 3 арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхойгүй байна. Үүнд:

ЗГҮАХХАХТ-ний:

- 167.4-ийн “Монгол Улсад импортоор орж ирж байгаа бүх хүнсний бүтээгдэхүүний шошгыг Монгол хэл дээр хөрвүүлж худалдаанд гаргах, цаашид импортоор оруулах бүх бараа бүтээгдэхүүний шошгыг Монгол хэл дээр хөрвүүлж худалдаанд гаргадаг болгоно”;
- 168.2-ын “Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээгээр дамжуулан биеийн тамираар идэвхтэй хичээллэж эрүүл, зөв амьдрах хэвшлийг дэмжих эрх зүйн орчин бүрдүүлнэ”;
- 173.1-ийн “Эрүүл мэндийн салбарт ажиллагсдыг төрийн албанаас гаргана”.

2.11 Хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн бодлогын зорилтуудыг дэмжсэн нийт арга хэмжээний хэрэгжилтийг хамрах хүрээгээр авч үзвэл,

Хүснэгт 8: Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний биелэлт, (тоо, хувь)

Д.д	Дэвшүүлсэн бодлого, зорилтын хамрах хүрээ	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилт	
				“0-30%”	“31-100%”
1	Иргэний ЭМД-ын шинэчлэлийг хийх	5	7	1	6
2	Эх орондоо чанартай оношилгоо, эмчилгээ хийлгэх боломжийг бүрдүүлэх	6	11	3	8
3	Орлого багатай иргэдийг ЭМД-д хамруулахад дэмжлэг үзүүлэх	2	3	-	3
4	Импортын эмийн болон хүнсний аюулгүй байдлыг хангах шинэчлэлийг хийх	2	10	2	8
5	Монгол хүний эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах	7	18	5	13
Нийт		22	49	11	38

Салбарын зорилт, арга хэмжээний болон үндсэн үзүүлэлт хүрэх түвшинд хүрч хангагдаагүй байна

2.12 Мөрийн хөтөлбөрийн биелэлтийг яамдаас тайлагнахдаа хэрэгжилтийн байдлыг хүргүүлсэн төдийгөөр асуудалд хандаж хөтөлбөрийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ иж бүрэн хийгдээгүй зөрчил нийтлэг байна.

2.13 Эрүүл мэндийн салбарт дэвшүүлсэн “Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний болон үндсэн үзүүлэлт хүрэх түвшинд хүрч хангагдахгүй, бодлого, шинэчлэлийн зорилтууд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй, цаг хугацааны хоцрогдолтойгоос зөвхөн салбарын бус онцгой анхааралд байж монгол хүний эрүүл мэнд, хүн амын нийтлэг эрх ашиг хангагдахгүйд хүрэх юм. *Зарим гол зорилт, арга хэмжээг нэрлэвэл:*

ЗГҮАХХАХТ-ний:

- Иргэний эрүүл мэндийн даатгалын шинэчлэлийг хийх (164);
- Эх орондоо чанартай оношилгоо, эмчилгээ хийлгэх боломж бүрдүүлэх нэгдсэн бодлого, төлөвлөлт хангалтгүй (165);
- Оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжийн угсралт, үйлдвэрлэл болон эм, эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж байгаа үндэсний аж ахуйн нэгжид судалгаа, боловсруулалт, үйлдвэрлэл, борлуулалт, маркетинг, дэд бүтцийн чиглэлээр дэмжлэг үзүүлэх (165.2);
- Орлого багатай иргэдийг ЭМД-д хамруулахад дэмжлэг үзүүлэх (166);
- Монгол хүний эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах (168);
- Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн сүлжээний хөрөнгө оруулалтын хэмжээг 2016 он гэхэд тав дахин нэмэгдүүлж, бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийг орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах (169).

2.14 Эрүүл мэндийн даатгалыг хөгжүүлэх урт хугацааны стратегийн баримт бичигт ЭМД-ын тогтолцоог шинэчилж, иргэдийг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, даатгуулагч бүр орлогын байдлаасаа үл хамааран аливаа санхүүгийн бэрхшээлгүйгээр, эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх эрх зүйн шинэчлэлийн энэхүү асуудал цаг хугацаа алдаж байна.

2.15 УИХ-ын 2014 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 57 дугаар тогтоолоор “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого” батлагдсанаар “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-д эмийн чанар, аюулгүй байдал, зохистой хэрэглээг сайжруулах талаар тусгах хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон үзэл баримтлал боловсруулагдсан ч эцэслэгдээгүй байна.

2.16 Эрүүл мэндийн сайдын 2013 оны 176 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлого”-ыг, 2014 оны 289 дүгээр тушаалаар “Эрүүл мэндийн технологийг 2014-2019 онд хөгжүүлэх төлөвлөгөө”-г баталсан ч анх төлөвлөсөн буюу шинэчлэх стандартууд тодорхой бус, тушаалын биелэлт хангалтгүй, хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

2.17 Сүүлийн 3 жилийн байдлаар /2012-2014 он/ гадаадад явж эмчлүүлэх зардалд дэмжлэг хүсч нийт 900 гаруй иргэн ЭМЯ-нд хандаснаас БНСУ-д 26 хувь, БНХАУ-д 17 хувь, БНЭУ-д 21 хувь тус тус эмнэлгийн тусламж, үйлчилгээ авахыг хүсч өргөдөл гаргасан бөгөөд энэ талаарх зорилтын хэрэгжилт хангалтгүй байна.

2.18 Дотооддоо оношлох, эмчлэх боломжгүй эмнэлэг, эмнэлгийн тусламж, үйлчилгээг эх орондоо бий болгох, бусад улсад эмчилгээнд хамрагдах өөрийн орны иргэдийн урсгалыг бууруулах, эмнэлгийн өндөр мэргэжлийн тусламжийг улсдаа нутагшуулах чиглэлээр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд зохих хэмжээгээр тодорхой ажлыг гүйцэтгэж байгаа боловч энэхүү үйлчилгээг дэмжсэн төрийн зохистой бодлого дэмжлэг дутагдалтай байна.

2.19 Гадаадад эмчилгээнд явах иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын багцад жил бүр 500.0 сая төгрөгийн санхүүжилт төсөвлөж байгаа бөгөөд сүүлийн 3 жилийн байдлаар нийт 503 хүнд 1.5 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгогдсон байна.

2.20 “Эмийн болон хүнсний аюулгүй байдлын систем”-ийн төслийг боловсруулан ажиллаж байгаа боловч хөрөнгө санхүүгийн дэмжлэггүйгээс зогсонги байна.

2.21 Монгол хүний эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах чиглэлийн хүрээнд “Эрүүл ахуйн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад нэмэлт оруулах үзэл баримтлал батлуулах, хүний эрүүл мэндэд орчны нөлөөлөх байдлын сэдэвчилсэн судалгаа хийж үнэлгээ өгөх түвшинд явагдаж байна.

2.22 “Нэг сувилагчид ногдох өвчтөний тоог олон улсын жишигт хүргэж өвчтөнд үйлчлэх асаргаа, сувилгааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх”, “Анагаахын боловсрол олгох, мэргэшил дээшлүүлэх, нарийн мэргэшлийн эмчийг дотоод, гадаадад бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох” зорилт арга хэмжээний хэрэгжих үндэслэл, эрх зүйн орчны шинэчилсэн журам гарсан ч түүнийг дагалдан хийгдэх ажлууд удаашралтай байна.

2.23 “Төрийн болон хувийн хөрөнгө оруулалтаар оношилгооны томоохон төвийг байгуулж, эх орондоо бүрэн оношлуулах нөхцөлийг бүрдүүлэх” 2012-2015 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч хэрэгжилт удаашралтай байна.

Бүлэг 3. Хөтөлбөрийн өнөөгийн үр дүнг харгалзан зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна

3.1 Монгол Улсын Их Хурлаас баталсан “Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх “Үндсэн чиглэл”-д² Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс 110 зорилт, арга хэмжээ тусгагдсан байна.

3.2 Гэвч ЗГҮАХХАХТ болон “Үндсэн чиглэл”-д тусгагдсан зарим зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний агуулга, хэрэгжүүлэх хугацаа, тэдгээрийн хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтийн хувьд зөрүүтэй байна. Тухайлбал,

- ЗГҮАХХАХТ-ний 2.1, 2.2, 2.3 дахь заалт ба үндсэн чиглэлийн 3.4-т тусгагдсан зорилт, арга хэмжээний шалгуур, 2015 оны хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт уялдаагүй;
- ЗГҮАХХАХТ-ний 111.1-ийн зорилт, үндсэн чиглэлийн 8.4-т батлагдсанаас хүчин чадал, хүрэх түвшин, агуулгын зөрчилтэй;
- ЗГҮАХХАХТ-ний 147.1 ба үндсэн чиглэлийн 2.1 дэх зорилтын хэрэгжих хугацаа зөрүүтэй,
- ЗГҮАХХАХТ-ний 119.3 ба үндсэн чиглэлийн 8.6-д тусгагдсан зорилт, арга хэмжээний шалгуур, 2015 оны хүрэх түвшин, шаардлагатай хөрөнгийн төсөвлөсөн эх үүсвэр харилцан адилгүй;
- ЗГҮАХХАХТ-ний 8 ба үндсэн чиглэлийн 12.3 дах зорилт, арга хэмжээний гол агуулга, хэрэгжүүлэгч байгууллага болон хугацаа, шалгуур, хүрэх түвшин өөр байх зэргээр эдийн засаг, нийгмийн хөгжлийн гол баримт бичгүүдийн уялдаа хангаагдахгүй байна.

3.3 Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж баталсан хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийн тооцооллын талаарх төлөвлөлт, судалгааны баримт алга байна.

3.4 Хэрэгжүүлэгч байгууллагууд хэрэгжилтийг хангахуйц санхүү, хөрөнгийн эх үүсвэр батлагдсан ч тэдгээр нь зохих хэмжээгээр хангагдаагүй, төлөвлөлтийн алдаатай бодлоготой холбон тайлбарлаж байгаа боловч бусад нөөц, эх үүсвэрийг ашигласан талаар болон ямар нэг зохистой шийдэл, нөхцөл байдалтай уялдуулсан шийдвэр гарган ажиллаагүй байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн төлөв байдалд үнэлэлт өгч, цаашид хэрэгжүүлэх гол асуудлыг тодорхойлох шаардлагатай байна

3.5 УИХ-аас Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжих эхний хагасын хугацаанд эдийн засаг, нийгмийн хөгжлийн хүрээний идэвхжлийг үл сааруулах, өсөлтийн хандлага, нөөцийг хадгалах, нарийвчилсан төлөвлөгөөтэйгээр ажиллан хууль тогтоомжийн дагуу баталгаажуулалт хийж ажиллах талаар зохих шийдвэрүүдийг гарган Засгийн газарт чиглэл өгч ирсэн байна.

3.6 ЗГХЭГ-аас “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 2013, 2014 оны байдлаар үнэлж, дүгнэсэн байдлыг судлан үзэхэд дараах байдалтай байна.

3.6.1 Ажилтай орлоготой монгол хүн хөтөлбөрийн 163 зорилтын хүрээнд 2013 оны хэрэгжилт 51.5, харин 2014 оны байдлаар 53.9 хувийн биелэлттэй гэж дүгнэгдсэн бөгөөд хөтөлбөрийн 1-ээс 55 хүртэлх үндсэн зорилтын хүрээний болон

² Монгол Улсын Их Хурлын 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” 53 дугаар тогтоол

үйлдвэржүүлэх, түүний дотор ашигт малтмал, уул уурхайд түшиглэх, үндэсний баялаг болсон мал, малаас гаралтай түүхий эдийг ашиглан үйлдвэрлэл хөгжүүлэх, үйлчилгээний биенесийг дэмжих зэрэг салбар дагнасан чиглэлээр дэвшүүлсэн бодлогын хэрэгжилт, идэвхжил сул байна.

Хүснэгт 9: ЗГХЭГ-ын тайлагнасан байдал (тоо, дундаж хувь)

Д.д	Хэрэгжүүлэх бодлогын чиглэл,хамрах хүрээ		Зорилтын тоо	Хэрэгжилт	
				2013 оны байдлаар	2014 оны байдлаар
Нэг. Ажилтай орлоготой Монгол хүн			163	51.5	53.9
Салбар, чиглэлүүд	1	Үйлдвэржүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого	12	34.4	43.4
	2	Ноос, ноолуур, арьс ширний чиглэлээр	3	36.6	46.6
	3	Уламжлалт МАА, мах, сүүний чиглэлээр	8	45	60.0
	4	Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэл	10	26.0	39.0
	5	Өндөр технологи, био, нано, мэдээллийн технологи	4	40.0	55.0
	6	Импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого	12	48.3	60.8
	7	Үйлчилгээний бизнесийг дэмжих чиглэл	39	39.2	47.4
	8	Хөдөлмөр эрхлэлтийн бодлого	5	68.0	74.0
	9	Нийгмийн хамгааллын бодлого	15	58.0	69.3

3.6.2 Хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн үндсэн зорилт, түүнийг дэмжсэн арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулахын тулд ахиц дэвшлийг үнэлэхийн зэрэгцээ бодлогын зорилтуудаар биелэгдэх болон хугацааны эцэст зорилтод бүрэн хүрч ажиллах боломжтой, мөн нэмэлт зохион байгуулалтын болоод тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай зохих арга хэмжээг эрэмблэн хүндрэлтэй асуудлаар тодорхой шийдвэр гарган ажиллах шаардлагатай байна.

Хүснэгт 10: Ажилтай орлоготой монгол хүн хөтөлбөрийн хэрэгжилтийн төлөв байдлын хураангуй

Бодлогын чиглэл, хамрах хүрээ	Үндсэн зорилт		Хэрэгжихэд хүндрэлтэй	Гол асуудлыг эрэмблэх	Биелэх боломжтой	Бүрэн биелсэн
	тоо	Биелэлт /дундаж %/				
Бодлогын зорилтуудыг дэмжсэн шинэчлэлийн хүрээний	36	48.1				
Уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх	19	47.4				
Үйлдвэржүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого	12	39.3				
Ноос, ноолуур арьс ширний чиглэлээр хэрэгжүүлэх бодлого	3	45.6				
Уламжлалт МАА, мах, сүүний чиглэлээр хэрэгжүүлэх бодлого	8	47.7				
Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэл	10	34.3				
Өндөр технологи, био, нано, мэдээллийн технологийн чиглэл	4	54.4				
Импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого	12	46.1				
Үйлчилгээний бизнесийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх бодлого	39	40.3				
Хөдөлмөр эрхлэлтийн бодлого	5	72.4				
Нийгмийн хамгааллын бодлого	15	63.8				

3.6.3 Эрүүл чийрэг монгол хүн хөтөлбөрийн үндсэн 22 зорилтын хүрээнд 2013 оны хэрэгжилт 42.4, харин 2014 оны байдлаар 49.0 хувийн биелэлттэй гэж дүгнэгдсэн бөгөөд “Эх орондоо чанартай оношилгоо, эмчилгээ хийлгэх боломжийг бүрдүүлэх”, “Орлого багатай иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулахад дэмжлэг үзүүлэх”, “Монгол хүний эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах”-д чиглэгдсэн зорилтуудын хэрэгжилт чанарын ахиц, үр нөлөө бүхий эерэг үр дагавар ажиглагдахгүй байна.

Хүснэгт 11: ЗГХЭГ-ын тайлагнасан байдал (тоо, дундаж хувь)

Д.д	Хэрэгжүүлэх бодлогын чиглэл, хамрах хүрээ	Зорилтын тоо	Хэрэгжилт	
			2013 оны байдлаар	2014 оны байдлаар
	Хоёр. Эрүүл чийрэг Монгол хүн	22	42.4	49.0
1	Иргэний эрүүл мэндийн даатгалын шинэчлэлийг хийх	5	50	50
2	Эх орондоо чанартай оношлогоо, эмчилгээ хийлгэх боломжийг бүрдүүлэх	6	50	50
3	Орлого багатай иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулахад дэмжлэг үзүүлэх,	2	50	30
4	Импортын эмийн болон хүнсний аюулгүй байдлыг хангах шинэчлэлийг хийх	2	50	50
5	Монгол хүний эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах	7	50	60

3.6.4 Эрүүл чийрэг монгол хүн хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн гол зорилт, түүнийг дэмжсэн арга хэмжээний хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтийн хувьд анхан шатанд тэдгээрийн боловсруулалт, тооцоолол хангалттай бус байгаа тул хэрэгжилтийг сайжруулахын тулд гол эрсдэлүүдийг тодорхой болгох, нэмэлт зохион байгуулалтын ажлуудыг хэрэгжүүлж биелэгдэх боломжийг бий болгох шаардлагатай байна.

Хүснэгт 12: Эрүүл чийрэг монгол хүн хөтөлбөрийн хэрэгжилтийн төлөв байдлын хураангуй

Бодлогын хамрах хүрээ	Үндсэн зорилт		Хэрэгжихэд хүндрэлтэй	Нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай	Биелэх боломжтой	Бүрэн биелсэн
	Тоо	Биелэлт /дундаж %/				
Иргэний эрүүл мэндийн даатгалын шинэчлэлийг хийх,	5	65.7				
Эх орондоо чанартай оношилгоо, эмчилгээ хийлгэх боломжийг бүрдүүлэх,	6	48.2				
Орлого багатай иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулахад дэмжлэг үзүүлэх	2	30.0				
Импортын эмийн болон хүнсний аюулгүй байдлыг хангах шинэчлэлийг хийх	2	39.6				
Монгол хүний эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах	7	43.0				

3.7 Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын ХШҮ-ний тогтолцоо, чадавхид чанарын ахиц гарахгүй байгаагаас үндсэн зорилтууд болон тэдгээрийг дэмжсэн арга хэмжээний хэрэгжилт, тайлагналд чанарын дэвшил ажиглагдаагүй, хөтөлбөрийн үндсэн зорилт, арга хэмжээний биелэлтийг харгалзах шалгуур үзүүлэлтээр баталгаажуулан үнэлгээ, дүгнэлт өгөх боломжийг бууруулж байна.

3.8 УИХ-ын 2015 оны “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай” 41 дүгээр тогтоолоор эдийн засгийг тогтворжуулах, өсөлтийг дэмжих чиглэлээр бодлогын зорилтуудыг томъёолж, богино болон дунд хугацаанд гаргах үр дүнг тодорхойлсны дээр Засгийн газарт нарийвчилсан төлөвлөгөө гаргах, хэрэгжээгүй заалт бүрээр хариуцлага тооцох, үр дүнгийн байдлыг хагас жил тутам танилцуулж байхыг үүрэг болгосон байна.

3.9 УИХ-ын тогтоолын дагуу Засгийн газрын 2015 оны 116 дугаар тогтоолоор³ нарийвчилсан төлөвлөгөөг баталсан бөгөөд түүнд дэвшүүлсэн зорилтын дагуу авах арга хэмжээ, үйл ажиллагаа, тэдгээрийн 2015, 2016 оны эхний болон сүүлийн хагас жилээр хүрэх үр дүнг хариуцагч байгууллагын хамт тусгасан байна.

³ Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө батлах тухай”

Нийгэм, эдийн засгийн байдлын зарим үзүүлэлтийн түүвэр судалгааны дүн

3.10 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Ажилтай орлоготой”, “Эрүүл чийрэг” монгол хүн хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой хамаарал бүхий гэж үзсэн эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшний зарим үзүүлэлтийг түүвэрлэн тэдгээрийн тогтвортой байдал, өсөлт, бууралтын хандлага, хэлбэлзэл зэргийг харгалзах зарим үзүүлэлтээс үзэхэд зорилтот түвшин хангагдаагүй, тохиолдол давтамжийн тоо өндөр, идэвхжил сул байна.

3.10.1 Тухайлбал, Засгийн газрын 2014 оны 68 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Яамдын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ээс⁴ түүвэрлэн 2014 оны биелэлтийг зорилтот түвшинтэй харьцуулан үзэхэд Хөдөлмөрийн яамны 9 үзүүлэлтээс хангагдаагүй 4, хангагдсан 5, ЭМСЯ-ны 9 үзүүлэлтээс зорилтот түвшинд хүрээгүй 5, хангагдаагүй 4, ХАХНХЯ-ны 2 үзүүлэлтээс биелсэн 1, биелээгүй 1 байна.

Зорилтот түвшин хангагдаагүй заримыг тодотговол “Ажиллах хүчний оролцооны түвшин”, “Хөдөлмөрийн насны хүн амд ажиллагсдын эзлэх хувь”, “ДНБ-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь”, “Эрүүл мэндийн төсвийн урсгал зардалд эрүүл мэндийн даатгалын эзлэх хувь”, “Нэг хүнд ногдох спортын барилга, байгууламжийн талбайн хэмжээний өсөлт”, “Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан хүнсний хангамж дээшилсэн өрхийн тоо” зэрэг үзүүлэлтийг нэрлэж болохоор байна. (Хавсралт В)

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг ЭЗХЯ тайлагнаагүй бөгөөд Сангийн яамны тайлагнасан зарим үзүүлэлтээс үзэхэд улсын өр (хувь өнөөгийн үнэ цэнээр буурсан байх), нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нэгдсэн төсвийн зарлага, мөн ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хувь гэсэн гол үзүүлэлт хангагдаагүй байна.

3.10.2 Түүнчлэн ХАХНХЯ /УНДЕГ/, ЭМСЯ-наас сар бүр гаргадаг мэдээлэлд суурилсан ҮСХ-ноос авсан зарим үзүүлэлтэд түүвэр хийж “Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт”, “Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага” болон “Эрүүл мэнд”-ийн үзүүлэлтийг⁵ 2007-2013 он, 2014 оны жилийн эцсийн урьдчилсан байдлаар буюу нийт 8 жилийн хугацаагаар хандлагыг авч үзэхэд:

- Хөдөлмөр эрхлэлтийн зарим үзүүлэлтийн түвшин тайлант жилүүдэд харилцан адилгүй үр дүнг үзүүлж байгаа бөгөөд хандлага тогтвортой бус байна.
- Ажилгүйдлийн даатгалын санд хандсан хүний тоо 2014 онд 2007 оныхоос 4 дахин, зарцуулсан хөрөнгийн дүн 17.9 дахин өссөн байна.
- Нийт дүнгээр халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 2013-2014 онд өмнөх жилүүдтэй харьцуулахад буурсан ч зарим халдварт өвчний тохиолдол нэмэгдсэн, тархалт өндөртэй хэвээр, мөн нас баралт болон хоног болоогүй нас баралт, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл төдийлөн буураагүй нь эрүүл мэндийн эрсдэл өндөр хэвээр байгааг харуулж байна. (Хавсралт Г)

3.10.3 Нийгэм, эдийн засгийн байдлын зарим үзүүлэлтийн түүвэр судалгаанаас харвал:

- Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ цаг хугацааны хувьд явцад өссөн ч салбарын бүтцэд төдийлөн өөрчлөлт орохгүй байна. Голлох салбаруудаар хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь сүүлийн 2 жилд хадгалагдаж байгаа байна.

⁴ Эх сурвалж: Монгол Улсын засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн “Үзүүлэлт батлах тухай” 68 дугаар тогтоолын дагуу гаргасан Хөдөлмөрийн яам, ЭМСЯ, ХАХНХЯ-ны тайлан

⁵ Эх сурвалж: ҮСХ, ХАХНХЯ-наас авсан мэдээ


- Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээний өсөлтийн хандлага сүүлийн 2 жилд буурсан, улсын нэгдсэн төсвийн зарлагын болон зээлийн өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь өндөр хэвээр байна.
- Засгийн газрын орлого ба зардал ДНБ-д харьцуулсан үзүүлэлтээр харгалзан тус тус өсөж байна.
- Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеийнхээс буурахгүй байгаа нь эдийн засагт болон иргэдийн худалдан авах чадвар, зээлийн хүүгийн түвшинд үзүүлэх сөрөг нөлөөлөл их, өсөлтийг сааруулахад хүргэж байна.
- Хүний хөгжлийн индексийн хувьд сүүлийн 2 жилийн байдлаар өсөлтийн хандлага хэвээр хадгалагдсан байна.
- Хүн амын амьжиргааны үзүүлэлтээр нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогоор зарлагаа бүрэн нөхөж чадахгүй, хуримтлал үүсгэх боломж хомс байгааг харуулж байна.
- Дэлхийн улс орнуудын “Хөгжлийн индексийн үзүүлэлт”-ээр 142 улсыг хамруулсан сүүлийн 5 жилд хэрхэн эрэмблэгдсэн⁶ байдлыг үзвэл эдийн засгийн хувьд манай улс 2014 онд 2012 оноос 18 байраар ахисан байна. (Хавсралт Д)

3.11 Түүнчлэн манай улс 2014 оны байдлаар 52 дугаарт жагсаж хөгжлийн индексээр сүүлийн жилд 5 байраар ахисан ба хамгийн сайн үзүүлэлтээр “Нийгмийн Чадавхи” буюу 25 дугаар байрт, харин хамгийн сул буюу “Эрүүл Мэнд”-ээр 91 дүгээр байрт эрэмблэгдсэн байна.

3.12 Манай улс НҮБХХ-ийн “Хүний хөгжлийн илтгэл 2014”-т тайлагнаснаар ХХИ-ийн түвшингээр⁷ хамрагдсан нийт 187 орноос 103 дугаар байрт, III дах бүлэг болох хөгжлийн индекс дунд зэрэг үзүүлэлттэй /I-IV бүлэг/ орнуудын 2-рт, улс орнуудын 2013 оны ХХИ-ийн эрэмбийг 2012 онтой харьцуулахад 3 байраар ахисан байна.

3.13 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн “Ажилтай орлоготой”, “Эрүүл чийрэг” монгол хүн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн хангалттай бус байгаад дүгнэлт хийх, Монгол Улсын Их Хурлаас гаргасан бодлогын шийдвэрүүдтэй уялдуулан зорилт, арга хэмжээг эрэмблэн биелэлтийн явцыг зохистойгоор хянан удирдах шаардлагатай байна.

Шигтгээ 1: Хөгжлийн индексийн үзүүлэлт*



Эх сурвалж: www.prosperity.com

⁶ Эх сурвалж: www.prosperity.com

⁷ Эх сурвалж: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүний хөгжлийн илтгэл-2014

Дүгнэлт: Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн “Ажилтай, орлоготой монгол хүн”, “Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийн зорилт бүрэн хангагдаагүй байна.
- Ажилтай орлоготой монгол хүн хөтөлбөрийн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд төсөвлөсөн нийт эх үүсвэрийн дөнгөж 9.7, 2012-2014 онд хэрэгжих арга хэмжээний санхүүжилтийн 27.2 хувь зарцуулагдсан байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Эрүүл мэндийн салбарт 2013 онд зарцуулагдсан хөрөнгийн тооцооллыг гаргаагүй бөгөөд 2014 оны байдлаар нийт төсөвлөсөн эх үүсвэрийн 12.4 хувь зарцуулагдсан байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчдын хариуцсан асуудлыг бүртгэлжүүлэх, хэрэгжилтийн байдлыг ил тод мэдээлэх, хэрэгжилт тайлагналын явцад хяналт тавихуйц цахим мэдээллийн тогтолцооны үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.
- Улсын Их Хурлаас батлан гаргасан эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх, эдийн засгийн хүндрэлээс гарах болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, үндсэн чиглэлийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээний уялдааг хангах, гол асуудлыг эрэмблэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн санал



МОНГОЛ УЛС ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2015 оны 04 дугаар
сарын 21-ны өдөр

Дугаар 88/1145

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Санал өгөх тухай

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Ажилтай орлоготой Монгол хүн”, “Эрүүл чийрэг Монгол хүн” хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад, дүгнэлт хэсгийн:

Тайлбар 1-ийг
үзнэ үү.

“Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг жигд хангахад хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэр дутагдалтай байсан нь ажиглагдаж байгаа боловч нөгөө талаас хэрэгжих суурь, нөхцлийг бүрэн хангаагүй, мөн хэрэгжилтийн явцад зохион байгуулалтын шуурхай, хяналт-мониторингийн арга хэмжээ тууштай хэрэгжихгүй байна.

Тайлбар 2-ыг
үзнэ үү.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын хариуцсан асуудлыг бүртгэлжүүлэх, хэрэгжилтийн байдлыг ил тод мэдээлэх, хэрэгжилт, тайлагналын явцад хяналт тавихуйц цахим мэдээллийн тогтолцоо үгүйлэгдэж байна” гэсэнтэй санал нийлэхгүй байна.

Засгийн газар нь Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт удаашралтай байгаа зорилт, арга хэмжээг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын 4 удаагийн хуралдааны тэмдэглэлээр Засгийн газрын гишүүд, холбогдох агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг өгч ажилласан.

“Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем”-ийн буюу www.unelgee.gov.mn-ийг төрийн байгууллагуудад шинээр нэвтрүүлж байгаа бөгөөд энэхүү системийг ашигласнаар төрийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагнах ажиллагааг нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх юм. Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас тус бүр 400-700 хуудас бүхий тайлан, мэдээ ирүүлдэг байсныг өөрчилж, тайлант жил гүйцэтгэсэн ажлын явцыг үнэлж, дүгнэх ажлыг бодитой болгож, төсвийн төлөвлөлтийг гүйцэтгэлийн үр дүнтэй холбон ахиц гаргахад чиглүүлж байна.

Засгийн газрын 2013 оны 9 дүгээр сарын 21-ны өдрийн 322 тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу аудитын болон хяналтын байгууллагын өгсөн дүгнэлт, зөвлөмжийг

ажил хэрэг болгож, хэрэгжүүлэх үүднээс “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө”-г боловсруулж, түүний дагуу авсан арга хэмжээг тайлагнаж байх зохицуулалтыг хийсэн болно.

“Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан тайланг улирал тутам Сангийн яаманд хүргүүлж, холбогдох мэдээллийг цахим хуудаснаа тогтоосон хугацаанд байршуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалган ажиллаж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



[Handwritten signature] С.БАЯРЦОГТ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн саналд өгөх тайлбар

Тайлбар 1

Тайланд зарчмын өөрчлөлт ороогүй тул засвар хийх шаардлагагүй.

Тайлбар 2

Төсвийн ерөнхийлөн захирагчдын хариуцсан асуудлыг бүртгэлжүүлэх, хэрэгжилтийн байдлыг ил тод мэдээлэх, хэрэгжилт тайлагналын явцад хяналт тавихуйц цахим мэдээллийн тогтолцооны үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна гэж найруулгын өөрчлөлт хийлээ.

Зөвлөмж: Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайдад:

- Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох боломжийг судалж, шийдвэрлэх;
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн төлөв байдалд үнэлгээ өгч хэрэгжих боломжтой ч хэрэгжилт дутуу, бодит нөхцөл байдлын улмаас хэрэгжүүлэх явцад гарсан хүндрэлтэй тулгамдсан асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэн баримт бичгүүдийн уялдааг хангаж ажиллах;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, чадавхийг сайжруулах, хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг үр дүнд чиглүүлсэн цахим тогтолцооны үр нөлөөг сайжруулах.

Эрүүл мэнд, спортын сайдад:

- Монгол хүний эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах, түүнийг тооцох, үнэлэх арга зүйн нэгдсэн зохицуулалтыг бий болгож хэрэгжүүлэх;
- Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт, оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмжийн хангалт, эмнэлэг, эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаар дэвшүүлсэн зорилтын хүрээний арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах.

Хөдөлмөрийн сайдад:

- “Ажилтай, орлоготой Монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын уялдаа, хэрэгжилт, үр дүнгийн хяналтыг сайжруулах.

Хавсралт А

“АЖИЛТАЙ ОРЛОГОТой МОНГОЛ ХҮН” ХӨТӨЛБӨРИЙН
БҮРЭН ХАНГАГДААГҮЙ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д.д	Хөтөлбөрт тусгагдсан зорилт <i>/зорилтын дугаар/</i>	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэг-жүүлэх хугацаа	Үндсэн хэрэг-жүүлэгч байгууллага	Хамтран хэрэг-жүүлэгч байгууллага	Үнэл-гээ
НЭГ.АЖИЛТАЙ ОРЛОГОТой МОНГОЛ ХҮН						
1	Орон сууцны зээлийн тогтолцоог шинэчлэх /3/	Орон сууцны санхүүжилтийн асуудлыг зохицуулсан хуулийн төсөл боловсруулна.	2012-2014	БХБЯ	ЭЗХЯ СЯ ХЗЯ Монголбанк	30
2		Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцыг дэмжих сан байгуулж, санхүүгийн механизмыг бүрдүүлнэ.	2013-2016	БХБЯ	ЭЗХЯ СЯ Монголбанк	30
3		Газрын тосны бүтээгдэхүүний үндэсний үйлдвэр байгуулна.	2013	ЭЗХЯ	УУЯ	30
4		Барилгын материалын нэр төрөл, эрэлт, нийлүүлэлтийн судалгааг гарган мэдээллийн сан байгуулна.	2013-2014	БХБЯ	ҮХААЯ БШУЯ	30
5		Замын-Үүд, Алтанбулаг, Гашуунсухайт, Шивээхүрэн, Боршоо, Бичигт, Ханги, Бургастай, Булган, Ханх, Зэлтэр боомтуудын батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үе шаттай боловсруулна.	2012-2015	БХБЯ	СЯ ХЗЯ ЭЗХЯ	30
6		Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонхны систем, тээвэр ложистикийг хэрэгжүүлэхэд олон улсын хууль эрх зүйн хүрээнд хөрш орнуудтай хэлэлцэн тохиролцох зарчмаар шийдвэрлэнэ.	2012-2015	ЭЗХЯ	ГХЯ Холбогдох яам Агентлаг	30
7		Хөрөнгийн бирж болон брокер, дилер компаниудыг чадавхижуулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2013-2015	ЭЗХЯ	СЗХ СЯ	30
8	Банк санхүү, бирж, мэдээллийн технологи, амралт цэнгээний болон агаарын замын зангилаа төв байгуулах ажлыг эхлүүлэх /10/	Ази, Европ, Америк тивийг холбосон агаарын замын оновчтой огтлолцол дээр тусгай хуулийн зохицуулалттай банк, санхүү, бирж, МТ, амралт цэнгээний болон агаарын замын зангилаа төв байгуулах, хэрэгжүүлэх асуудлыг судалж зохицуулах үүрэг бүхий төслийн баг ажиллуулна.	2013-2014	ЭЗХЯ	БХБЯ ЭХЯ ЗТЯ ССАЖЯ МТШХХГ СЗХ ХЗЯ	10
9		Зангилаа төвийн үйл ажиллагааг зохицуулах тусгайлан хуулийн төсөл боловсруулна	2013-2014	ЭЗХЯ	ХЗЯ	10
10		Зангилаа төвийн байршлыг оновчтой сонгох, техник, эдийн засгийн үндэслэл, ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл боловсруулах, төвийн дэд бүтэц, барилгажилтын ажлыг эхлүүлэх арга хэмжээ авна.	2014-2016	ЭЗХЯ	БХБЯ ЭХЯ ЗТЯ ССАЖЯ МТШХХГ СЗХ ХЗЯ	-
11		Зангилаа төвийн бүхий л үйл ажиллагаанд МТ-ийн орчин үеийн тех/техн-ийн дэвшлийг нэвтрүүлж ашиглана.	2012-2015	ЭЗХЯ	МТШХХГ	-
12	Инфляцийг нэг оронтой тоонд барьж, төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой байлгах; /12/	ТМБТБҮЧ-ийн хүрээнд мөнгөний бодлогын арга хэрэгслээр инфляцийг нам түвшинд тогтвортой байлгаж, нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг хязгаарлах бодлого баримтална.	2012-2016	МБ	БХБЯ СЯ	-
13		“Зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд мөнгөний болон төсвийн бодлогыг уялдаатай, мөчлөг сөрсөн байдлаар явуулж, инфляцийг нам түвшинд тогтвортой байлгах макро нөхцлийг бүрдүүлнэ.	2012-2014	МБ		-
14	Хөрөнгө оруулалтыг тав хүртэл жилээр	Улсын хөр/ор-тын хөтөлбөрийг хөгжлийн бодлого төлөвлөлт, санхүүгийн эх үүсвэр, материал хангамж, ажиллах хүчний хүчин чадал зэрэг үзүүлэлттэй уялдуулан жил бүр тодотгож байна.	2012-2016	ЭЗХЯ	СЯ	30

15	төлөвлөх зарчимд шилжих /15/	Хөрөнгө оруулалтын ТАХ-г хэрэгжүүлэх үе шат бүрт гүйцэтгэх ажилбаруудын норм, норматив, стандартыг нарийвчлан тогтооно.	2012-2013	ЭЗХЯ	СХЗГ	30
16	Мөнгөний бодлогыг бодит эдийн засгийг дэмжихэд чиглүүлэх /21/	Эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөл болсон макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэхэд мөнгөний бодлогыг чиглүүлнэ.	2012-2016	МБ	ЭЗХЯ	-
17	Бусад улстай хийсэн давхар татварын гэрээг Монгол улсын эрх ашигт нийцүүлэн шинэчлэх, эсхүлхүчингүй болгох /25/	БНХАУ, Канад болон Сингапур Улстай байгуулсан давхар татварын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хэлэлцэн тохирогч улсуудтай хэлэлцээр хийж, санал холбогдох төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ.	2012-2016	СЯ	ГХЯ ЭЗХЯ	30
18	Төсвийн хөрөнгөөр худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээг нийлүүлэх ААН-д нийт борлуулалтын гучаас доошгүй хувийг өөрийн үйл ажиллагааны орлогоос олдог байх шаардлага тавих; /27/	ТБОНӨХБАҮХАТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулж, үүнтэй уялдуулан тендерийн бичиг баримт, үнэлгээний зааварт холбогдох өөрчлөлтийг оруулан, төсвийн ерөнхийлөн захирагч нараар мөрдүүлж ажиллана.	2012-2015	СЯ	ХААГ	-
19	Хөдөлмөрийн багтаамж ихтэй салбаруудыг бодлогоор дэмжиж ажлын байр нэмэгдүүлэх /30/	Боловсрол, эрүүл мэнд, уул уурхайн салбарт шаардлагатай оёмол бүтээгдэхүүнийг үндэсний ААН-үүдээр гүйцэтгүүлэх бодлого баримтлан /зээл/ дэмжлэг үзүүлнэ.	2012-2014	ҮХААЯ	БШУЯ	11
20		“Барилгын салбарын хөдөлмөр зуучлалын алба”-ыг өргөжүүлж үйл ажиллагааг нь идэвхжүүлнэ.	2012-2014	БХБЯ		30
21		Нийслэл хот, аймгийн төвд цаас, хэвлэлийн туслах материал, сав, баглаа боодлын үйлдвэрийг цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн парк хэлбэрээр хөгжүүлнэ.	2012-2014	ҮХААЯ		30
22		“Барилгын салбарыг 2013-2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлнэ.	2013-2016	БХБЯ	ЭЗХЯ СЯ	10
23	Хөдөө аж ахуйн биржийн тухай хууль, Улсын Их Хурлаас баталсан “Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр”	Орон сууцны багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.	2013-2014	БХБЯ	ХЗЯ	20
24	“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”	Барилгын материалын парк, бөөний худалдааны сүлжээг Замын-Үүд, Улаанбаатар хотод байгуулна.	2013-2016	БХБЯ	ЭЗХЯ	20
25	Засгийн газраас баталсан “Хүнсний аюулгүй байдал” “Монгол улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр”-үүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх /34/	Орон нутагт барилгын материалын түүхий эдийн геологи хайгуул хийж, нөөцийг тогтооно.	2012-2014	БХБЯ	ҮХААЯ ЭЗХЯ	10
26		Нийтийн зориулалттай орон сууцны лифт засварын цех байгуулж, ашиглалтын шаардлага хангахгүй 100-аас доошгүй лифтийг жил бүр шинэчилнэ.	2012-2016	БХБЯ	МХЕГ	30
27		Улаанбаатар хотын төвийн хөдөлгөөний нягтрал ихтэй хэсгүүдэд газар доорх инженерийн шугам сүлжээг хонгилын системтэйгээр төлөвлөж, шинэчлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.	2012-2016	БХБЯ	ЭХЯ	30
28	Санхүүгийн секторын шинэтгэлийг бодит сектор, тухайлбал, уул уурхайн бус эдийн засгийн бусад салбар, жижиг, дунд бизнесийн өсөлтийг дэмжих, хувийн даатгалын ба хөрөнгө оруулалтын сангууд, хувийн тэтгэврийн сангийн болон	Хувийн тэтгэврийн даатгалыг улсын тэтгэврийн даатгалын тогтолцооны нэмэлт давхарга хэлбэрээр хөгжүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	2013-2014	ХАХНХЯ	ХАХНХЯ	10
29		Хувийн тэтгэврийн даатгалын сангуудын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтад хяналт тавих тогтолцоо бий болгож, сангуудын эрсдэлийг бууруулан, хувийн тэтгэврийн сангаар дамжуулан санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжинэ.	2013-2014	ХАХНХЯ	ЭЗХЯ СЗХ	10

	зээлийн батлан даалтын тогтолцоог хэрэгжүүлэх чиглэлээр орчин үеийн санхүүгийн зах зээлийн өрсөлдөөнт орчныг бий болгоход чиглүүлэх /35/					
30	Нутаг дэвсгэрийн геологийн зураглал, эрэл, хайгуулын ажилд зарцуулж байгаа улсын төсвийн хөрөнгө оруулалтыг жил бүр нэмэгдүүлж, геомэдээллийн санг баяжуулах, эрдэс баялгийн нөөцийг өсгөн нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарыг тогтвортой хөгжүүлэх бодлогыг дэмжих /37/	Эрдэс, чулуулгийн лабораторийн шинжилгээ, судалгааг боловсронгуй болгож, олон улсын түвшинд хүрсэн чанарын болон тоон шинжилгээг иж бүрэн хийдэг болно.	2012-2016	УУЯ		30
31	Геологийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд Монголын Үндэсний геологийн албыг шинээр байгуулах /39/	Монголын Үндэсний геологийн албыг шинээр байгуулах асуудлыг судалж шийдвэрлэнэ.	2012-2013	УУЯ		30
32	Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох /40/	Ашигт малтмалын олборлолт явуулах үед байгаль орчныг хамгаалах болон олборлолт явуулсны дараа байгаль орчныг нөхөн сэргээх зардлыг төрийн санд урьдчилан төвлөрүүлдэг болгоно.	2012-2014	УУЯ	БОНХЯ	30
33	Алтны олборлолт, хадгалалт, борлуулалтыг ил тод болгох /44/	Сорьц тогтоох лабораторид шинжлүүлсэн үнэт металлыг Монголбанк руу зөөвөрлөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.	2013-2014	СХЗГ	СЯ Монгол Банк	-
34	Байгалийн нөөцийн эдийн засгийн статистикийг шинэчилж, улсын эдийн засаг, санхүүд эрдэс баялгийн салбарын үзүүлж байгаа нөлөөллийн үзүүлэлтийг системтэй тооцоолох аргачлалыг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох /48/	Байгаль орчны эдийн засгийн судалгаа хийж, статистик үзүүлэлтийг боловсронгуй болгон үндэсний тооцооны системд тусгах арга хэмжээ авна	2012-2016	БОНХЯ	ЭЗХЯ ҮСХ	25
35	Эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг хангахын тулд ашигт малтмалыг түүхий эд хэлбэрээр гаргахыг үе шаттай багасгах, түүнчлэн экспортолж байгаа бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг олон улсын стандартад нийцүүлэн шат дараатай ахиулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх бодлого баримтлах /49/	Уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2013	ҮХААЯ	УУЯ СЯ ХЗЯ	30
36		Зэсийн баяжмалыг боловсруулан цэвэр зэс үйлдвэрлэх технологийн сонголт хийж, үйлдвэрийн ТЭЗҮ-ийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар гүйцэтгүүлнэ.	2015-2016	ҮХААЯ	ЭЗХЯ	30
37		Зүүн бүст полиметаллын баяжмалыг боловсруулан цайр болон бусад дагалдах элементийг ялган авах үйлдвэр байгуулах асуудлыг судалж шийдвэрлэнэ.	2013-2014	ҮХААЯ	ЭЗХЯ	10

38	Гадаадын шууд хөрөнгө оруулагчидтай харилцан ашигтай байх зарчмыг баримтлан ажиллах. уул, уурхай, эрчим хүч, газрын тосны салбарт өмнө нь байгуулсан тогтвортой байдлын, хөр/ор-ын, БХГ-нд өөрчлөлт оруулах асуудлыг судалж, холбогдох өөрчлөлтүүдийг хөрөнгө оруулагч талтай харилцан тохиролцож хийх /51/	Оюутолгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахтай холбогдуулан Улсын Их Хурлын шийдвэрүүд, тус төслийн хэрэгжилтийн явцад гарч байгаа зарим тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор уг ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах талаар хөрөнгө оруулагч талтай өмнө нь хийсэн яриа хэлэлцээг үргэлжлүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллана.	2012-2016	ЭЗХЯ	УУЯ СЯ	30
39	Тусгай зөвшөөрлийн арилжаанд ил тод байдлыг бүрдүүлэх /53/	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг цахим үйлчилгээнд бүрэн шилжүүлнэ.	2013	МТШХХГ		10
40	Уул уурхайн салбарын түүхий эдэд нэмүү өртөг шингээх бодлого хэрэгжүүлэн хагас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, экспортолж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг татварын бодлогоор хөхиүлэн дэмжих /55/	Уул уурхайн түүхий эд ашиглан нэмүү өртөг шингэсэн хагас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гадаад, дотоод зах зээлд нийлүүлж байгаа үйлдвэрлэгчдийг татварын бодлогоор дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2013-2016	ҮХААЯ	УУЯ ЭЗХЯ СЯ ХЗЯ	30
1.Үйлдвэржүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого						
41	Уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулах зорилгоор аж үйлдвэрийн анхны паркийг Дорноговь аймгийн Сайншанд хотод байгуулах /56/	Чойрын 220 кВ-ын дэд станцыг өргөтгөнө.	2013-2016	ЭХЯ	УУЯ	25
42		Чойр-Сайншандын 2 хэлхээт 220 кВ-ын 220 км шугам, дэд станцыг барина.	2013-2016	ЭХЯ	УУЯ	15
43		“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг эдийн засаг, татварын бодлогоор дэмжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ.	2012-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ	30
44		“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний байгууламжийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэнэ.	2013-2016	ҮХААЯ	ЭЗХЯ БХБЯ ЭХЯ ЗТЯ	30
45		“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын мастер төлөвлөгөөнд тусгагдсан үйлдвэрийг хувийн хэвшлийн үүсгэл санаачлагад тулгуурлан байгуулж эхэлнэ.	2014-2016	ҮХААЯ	ЭЗХЯ БХБЯ ЗТЯ ЭХЯ	30
46		“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын хүрээнд бетон зуурмагийн үйлдвэр байгуулна.	2014	БХБЯ	ЭЗХЯ ҮХААЯ	-
47		“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборыг дагаж хөгжих хөнгөн үйлдвэрийг байгуулж эхэлнэ.	2012-2014	ҮХААЯ	ЭЗХЯ СЯ	10
48	Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүс, Алтанбулаг болон Цагааннуурын чөлөөт бүсийн дэд бүтцийг цогцоор нь барьж дуусгах /58/	Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуурын чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.	2012-2014	ЭЗХЯ	ЭЗХЯ	30
49	“Чойр”, “Багахангай” ложистик төвийн эхний ээлжийн дэд бүтцийг барьж байгуулах /59/	“Чойр”, “Багахангай” ложистик төвийн эхний ээлжийн дэд бүтцийг улсын төсвийн хөр/оруулалт болон концессын гэрээгээр барьж байгуулна.	2013-2014	ЭЗХЯ		-

50	Уул уурхайн бус экспортыг дэмжих, хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хувийн хэвшлийн оролцоо, манлайлалтай боловсруулан хэрэгжүүлэх. Уул уурхайн салбарын экспортын орлогын тодорхой хэсгээс уул уурхайн бус экспортын хөгжлийн сан байгуулах /60/	Уул уурхайн салбарын экспортын орлогоос хуримтлал үүсгэн, уул уурхайн бус экспортын хөгжлийг дэмжих Инновацийн сан байгуулж, өндөр болон ногоон технологи, СЭХ зэрэг чиглэлээр дэвшилтэт технологийг нэвтрүүлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох компаниудад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	2013-2016	ЭЗХЯ	СЯ УУЯ ҮХААЯ	30
51	Уул уурхайн салбарын экспортын орлогын тодорхой хэсгээс уул уурхайн бус экспортын хөгжлийн сан байгуулах /60/	ЖДҮ-ийн салбарт оюуны өмчийн тогтолцоог ашиглах санхүүгийн хөшүүргийг бий болгож дэмжлэг үзүүлнэ.	2013-2014	ЭЗХЯ	ОӨГ	10
52	Уул уурхайн бус экспортын хөгжлийн сан байгуулах /60/	Биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээний тогтолцоог бүрдүүлж бизнесийн үйл ажиллагаанд нэвтрүүлж хэвшүүлнэ.	2014	ЭЗХЯ	ОӨГ	30
53	ДХБ-д элсэхдээ хүлээсэн үүргийн дагуу гааль, тарифын механизмыг ашиглан үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах асуудлыг шийдвэрлэх /61/	Импортын гаалийн тарифын ерөнхий түвшин 20 хувь байх зарчмыг баримтална.	2013-2016	СЯ		-
54	Уул уурхайн салбарын экспортын орлогын тодорхой хэсгээс уул уурхайн бус экспортын хөгжлийн сан байгуулах /60/	Экспорт, импортын бараанд нэр төрөл, бүс нутаг, үйлдвэрлэгчээр ялгавартай тариф тогтооно.	2013-2016	СЯ		-
55	Уул уурхайн бус экспортын хөгжлийн сан байгуулах /60/	Импортын буудай, гурил, хүнсний ногооны гаалийн албан татварын хувь хэмжээг ДХБ-ын гэрээ хэлэлцээрийн хүрээнд нэмнэ.	2013-2014	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ	30
56	Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, цемент, төмөр хийц, шил, дулаалгын материал зэрэг бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого баримтлах /62/	Хаягдал шилийг ашиглаж бетон дүүргэгч шилэн блокны үйлдвэр байгуулна.	2013-2016	БХБЯ	ЭЗХЯ	10
57	Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, цемент, төмөр хийц, шил, дулаалгын материал зэрэг бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого баримтлах /62/	Дулаан тусгаарлах материалын үйлдвэрлэлийг дэмжиж, хөнгөн дүүргэгч, хөнгөн бетон, эрдэс хөвөн, хонины ноосон дулаалгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг 100 хувь хангана.	2013-2016	БХБЯ	ЭЗХЯ	30
58	Баруун бүсийн нүүрсний ордуудыг түшиглэн 60-100 МВт-ын дунд чадлын цахилгаан станц барих /65/	Баруун бүсийн нүүрсний ордуудыг түшиглэн ДЦС барих ажлыг эхлүүлнэ.	2012-2015	ЭХЯ	ЭЗХЯ СЯ	-
59	Дотоодын эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох улс болох /67/	Оюутолгойн 450 МВт-ын ДЦС-ыг барьж байгуулна.	2012-2016	ЭХЯ	ЭЗХЯ СЯ	-
60		Баянтээгийн 40 МВт-ын ДЦС-ын ТЭЗҮ-ийг боловсруулж барина.	2013-2016	ЭХЯ	ЭЗХЯ СЯ	5
61		Эрдэнэтийн ДЦС-ын хүчин чадлыг 30 МВт-аар нэмэгдүүлнэ	2012-2015	ЭХЯ	ЭЗХЯ СЯ	20
62		УБ-Мандалговийн 330 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, дэд станц барина	2013-2016	ЭХЯ	ЭЗХЯ СЯ	25
63		Багануур-Өндөрхаан-Чойбалсангийн 220 кВ-ын ЦДАШ, дэд станцыг барина.	2013-2014	ЭХЯ	ЭЗХЯ СЯ	30
2.Ноос, ноолуур, арьс ширний чиглэлээр хэрэгжүүлэх бодлого						
64	Малын гаралтай түүхий эд, ноолуур, ноос, арьс ширийг боловсруулж, зах зээлд нийлүүлдэг болох /69/	Боловсруулах үйлдвэрт хонь, тэмээний ноос тушаасан малчдад урамшуулал олгодог болно.	2012-2014	ҮХААЯ		30
65	Дархан-Уул аймаг, нийслэл хотын гадна байгаль орчинд ээлтэй, хаягдлаа бүрэн боловсруулах чадвартай арьс шир боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжих /70/	Улаанбаатар, Дархан хотын гадна талд арьс ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах дэд бүтцийг барьж эхэлнэ.	2012-2014	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ БШУЯ	30
3.Уламжлалт мал аж ахуй, мах сүүний чиглэлээр хэрэгжүүлэх бодлого						

66	Хангайн бүсийн аймгуудад өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй, говь хээрийн бүсэд өндөр ашиг шимт хонь, ямааны аж ахуйг дэмжиж, тариалангийн бүс нутагт дэвшилтэт технологи бүхий ФАА-г хөгжүүлэх /72/	Улаанбаатар хотыг эрүүл, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой хангах зорилгоор “Стратегийн хүнсний биотехнологийн үйлдвэрлэл, хөгжлийн загвар бүс” төслийг хэрэгжүүлнэ.	2012-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ БШУЯ	30
67	Эрчимжсэн мал аж ахуй, гахай, шувууны аж ахуй эрхэлж байгаа аж ахуйг дэмжих зээлийн санг 50 тэрбумаас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй байгуулах /75/	Мал хамгаалах санд эрчимжсэн аж ахуйг дэмжих зээлийн эргэлтийн сан бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлж, зээл олгоно.	2013-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ	30
68	Тариалангийн бүсэд гахайн цогцолбор аж ахуй хөгжүүлэхэд зээлийн дэмжлэг үзүүлж, гахайн мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Тариалангийн бүсэд гахайн цогцолбор аж ахуй хөгжүүлэхэд зээлийн дэмжлэг үзүүлж, гахайн мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2013-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ	30
69	Хот суурингийн ойролцоо шувууны аж ахуйг хөгжүүлэхэд зээлийн дэмжлэг үзүүлж, өндөгний хэрэгцээг бүрэн хангана.	Хот суурингийн ойролцоо шувууны аж ахуйг хөгжүүлэхэд зээлийн дэмжлэг үзүүлж, өндөгний хэрэгцээг бүрэн хангана.	2013-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ	30
70	Газар тариалан, фермерийн бүс нутгийг түшиглэн хуурай сүү боловсруулах үйлдвэр, аймгуудад цөцгийн тос болон сүүн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахыг дэмжих /76/	Хоногт 30 тн сүү боловсруулах хүчин чадалтай хуурай сүүний үйлдвэр байгуулна.	2013-2016	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ	30
71	Баруун болон төвийн бүсийн аймгуудад хоногт 1 тн-оос доошгүй сүү боловсруулах хүчин чадалтай үйлдвэр байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлнэ.	Баруун болон төвийн бүсийн аймгуудад хоногт 1 тн-оос доошгүй сүү боловсруулах хүчин чадалтай үйлдвэр байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлнэ.	2013-2014	ҮХААЯ		30
72	Мал нядалгааны үйлдвэр, цехэд 3-7 дугаар сард мал нийлүүлсэн малчдад урамшуулал олгоно.	Мал нядалгааны үйлдвэр, цехэд 3-7 дугаар сард мал нийлүүлсэн малчдад урамшуулал олгоно.	2013-2015	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ	10
73	Биржээр малын худалдаа зохион байгуулах ажлыг сум бүрт туршилтын журмаар зохион байгуулна.	Биржээр малын худалдаа зохион байгуулах ажлыг сум бүрт туршилтын журмаар зохион байгуулна.	2014-2015	ҮХААЯ	ЭЗХЯ	30
74	Хөргөлттэй агуулах, лангуу, тоног төхөөрөмж бүхий махны төрөлжсөн зах байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлнэ.	Хөргөлттэй агуулах, лангуу, тоног төхөөрөмж бүхий махны төрөлжсөн зах байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлнэ.	2013-2015	ҮХААЯ	ШӨХТГ	30
75	Улаанбаатар хот болон загасны нөөцтэй аймгуудад загас боловсруулах үйлдвэр байгуулна.	Улаанбаатар хот болон загасны нөөцтэй аймгуудад загас боловсруулах үйлдвэр байгуулна.	2013-2015	ҮХААЯ	БОНХЯ ХЯ	30
76	Төрөөс малчдын талаар баримтлах бодлого, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, мал эмнэлэг, үржлийн төрийн үйлчилгээний албыг бүх суманд бэхжүүлэх /78/	Малын үржлийн үйлчилгээний нэгжийн хүртээмжийг нэмэгдүүлж, гойд ашиг шимт мал, үр импортоор оруулж, үржлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болно.	2014-2016	ҮХААЯ		30
77	Малын эрүүл мэнд, хорио цээрийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, мал эмнэлгийн албаны үндэсний тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн, малын гаралтай бүтээгдэхүүнийг экспортлох нөхцөлийг бүрдүүлнэ.	Малын эрүүл мэнд, хорио цээрийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, мал эмнэлгийн албаны үндэсний тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн, малын гаралтай бүтээгдэхүүнийг экспортлох нөхцөлийг бүрдүүлнэ.	2012-2016	ҮХААЯ	МХЕГ	30
4.Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого						
78	Аялал жуулчлалын салбарын бодлогыг тогтвортой хөгжлийн зарчимд нийцсэн жуулчлалын төрлүүд, түүний дотор тусгай сонирхлын, байгалийн, соёлын аялал жуулчлалыг бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлэх /79/	Орон нутагт тусгай сонирхлын, байгалийн, соёлын аялал жуулчлалыг төрөлжүүлэн хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2014-2015	ССАЖЯ	ЭЗХЯ	10
79	Хүүхэд, залуучуудад зориулсан байгалийн, танин мэдэхүйн болон нүүдлийн соёлын чиглэлээр дотоодын аялал жуулчлалыг дэмжинэ.	Хүүхэд, залуучуудад зориулсан байгалийн, танин мэдэхүйн болон нүүдлийн соёлын чиглэлээр дотоодын аялал жуулчлалыг дэмжинэ.	2012-2016	ССАЖЯ		30

80	Монгол Улсын байгалийн үнэт баялаг болсон хангайн бүсэд ашигт малтмал олборлохыг хуулиар хязгаарлаж, байгалийн унаган төрхийг хэвээр хадгалан аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх /80/	Хөвсгөл аймагт Алунгоо эхийн цогцолбор байгуулна.	2015-2016	ССАЖЯ	ЭЗХЯ	10
81	Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор зах зээлийн эрэлтэд нийцсэн парк, музей, цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтарсан хөрөнгө оруулалтаар барьж байгуулахыг дэмжих /82/	Баруун бүсэд олон ястны соёлын парк байгуулах ажлыг эхлүүлнэ.	2015-2016	ССАЖЯ	БХБЯ	-
82		Хархоринд “XIII зуун” цогцолбор байгуулна.	2013-2016	ССАЖЯ	ЭЗХЯ	10
83		Хөвсгөл аймагт цаатан угсаатны музей байгуулна.	2014-2015	ССАЖЯ		30
84	Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу нийтийн ариун цэврийн газар, иж бүрэн үйлчилгээ бүхий түр буудаллах цэг байгуулахыг дэмжих /83/	Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу түр буудаллах цэг байгуулахад хөрөнгө оруулагчдыг дэмжинэ.	2014-2015	ССАЖЯ	СЯ	30
85		Аялал жуулчлалын бааз, нийтийн үйлчилгээний газруудад бохир усыг цуглуулах, цэвэрлэх технологи бүхий бага оврын цэвэрлэх байгууламжийг нэвтрүүлнэ.	2012-2016	БХБЯ	ССАЖЯ БОНХЯ	30
86	Говийн аялал жуулчлалын бүс, Орхоны хөндийн аялал жуулчлалын бүс, Хөвсгөл нуурын аялал жуулчлалын бүсийг холбосон дэд бүтэц байгуулах /85/	Говийн аялал жуулчлалын бүс, Орхоны хөндийн болон Хөвсгөл нуурын аялал жуулчлалын бүсийн хөгжлийн төслийг боловсруулж батална.	2014-2016	БХБЯ	БОНХЯ СЯ ЭЗХЯ	10
87		Хархоринг байгаль орчинд ээлтэй хот болгон хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулж батална.	2014-2015	БХБЯ	БОНХЯ СЯ ЭЗХЯ	10
88		Орхоны хөндий, Хөвсгөл нуурын аялал жуулчлалын бүсэд цахилгаан эрчим хүчний дэд бүтцийг барина.	2014-2016	ЭХЯ	СЯ ЭЗХЯ	35
